



**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Сорил зохион байгуулах арга зүйн  
сургалт, семинар явуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2013 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит бие бялдар, хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг зохион байгуулах арга зүйн сургалт семинарыг 2014 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын "Хангарьд" ордны 14 давхрын "Б" танхимд зохион байгуулсугай.
2. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалт семинарт шаардагдах 620.000 /зургаан зуун хорин мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төвлөрсөн төсвийн сургалт семинар, зөвлөгөөний зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
4. Сургалт семинарыг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500113